



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ургамал сумын ЕБС-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/78/СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч : Г.Заяа Утас:92038288 Цахим хаяг: zayaq@audit.gov.mn</p> <p>Аудитор: Д.Пүүжмаа Утас:99080797 Цахим хаяг: puujmaad@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

2022.02.24 № 1302/404
танай _____ -ны № _____ -т

УРГАМАЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Г.АЛТАНСАРНАЙ -д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ургамал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Ургамал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Ажилтнуудад үр дүнгийн урамшууллыг 328.4 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон, өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтны цалинг 2,510.0 мянган төгрөгөөр илүү тогтоож олгосон, Үдийн цайны зардлаас 11,429.7 мянган төгрөгийг бараа материалын тайлангаар дамжуулалгүй шууд зардлаар тайлагнасан зэрэг зөрчил нь, (Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтууд, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 06/1476 тоот албан бичиг, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.2 дах заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй) байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Audit(D)A4-тоот/2022

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

012625447

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>50,787,824.20</u>	<u>51,726,490.33</u>
33	АВЛАГА	1,748,211.87	1,400.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.19	-
335	Бусад авлага	1,748,211.68	1,400.00
3351	Байгууллагаас авах авлага	1,746,811.68	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,400.00	1,400.00
35	БАРАА МАТЕРИАЛ	49,039,612.33	51,725,090.33
351	Түүхий эд материал	9,878,867.15	13,265,867.15
35110	Тусгай зориулалттай материал	9,341,037.15	12,461,037.15
35130	Эм боох материал	537,830.00	804,830.00
354	Хангамжийн материал	39,160,745.18	38,459,223.18
35410	Бичиг хэргийн материал	1,109,250.00	373,300.00
35420	Аж ахуйн материал	26,396,429.18	28,039,929.18
35440	Түлш, шатах тослох материал	232,000.00	232,000.00
35450	Барилгын засварын материал	710,000.00	710,000.00
35460	Хүнсний материал	4,586,666.00	521,022.00
35470	Бусад хангамжийн материал	6,126,400.00	8,582,972.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>495,960,034.59</u>	<u>462,641,468.91</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	495,960,034.59	462,641,468.91
391	Газар		
392	Биет хөрөнгө	435,990,034.59	402,774,593.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	442,997,556.00	442,997,556.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(103,119,946.68)	(126,912,879.60)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	16,335,000.00	16,335,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(7,584,999.90)	(10,084,999.86)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	127,427,314.01	127,427,314.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(92,061,399.25)	(94,455,409.98)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	66,615,727.22	66,615,727.22
39208	Хуримтлагдсан элэгдэл	(40,881,033.65)	(45,384,265.64)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,441,200.00	9,441,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,381,183.32)	(4,371,448.40)
39217	Ном	20,201,800.16	21,166,800.16
393	Биет бус хөрөнгө	59,970,000.00	59,866,875.00
39301	Програм хангамж	2,400,000.00	2,400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(750,000.00)	(853,125.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	58,320,000.00	58,320,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>546,747,858.79</u>	<u>514,367,959.24</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>20,356,122.90</u>	<u>21,992,372.90</u>

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,356,122.90	21,992,372.90
413	Өглөг	20,356,122.90	21,992,372.90
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,099.90	3,099.90
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	20,349,000.00	21,985,250.00
4136	Бусад өглөг	4,023.00	4,023.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	4,023.00	4,023.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	526,391,735.89	492,375,586.34
51	Засгийн газрын хувь оролцоо	526,391,735.89	492,375,586.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	436,727,137.20	436,727,137.20
51101	Өмч: - төрийн	436,727,137.20	436,727,137.20
512	Хуримтлагдсан үр дүн	(241,224,742.43)	(275,240,891.98)
51210	Өмнөх үеийн үр дүн	(241,224,742.43)	(242,971,554.11)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(32,269,337.87)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	330,889,341.12	330,889,341.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	546,747,858.79	514,367,959.24

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	624,470,995.00	620,761,743.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,542,594.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	12,542,594.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,542,594.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,585,600.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,956,994.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	611,928,401.00	620,761,743.27
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	492,684,100.00	587,746,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	492,684,100.00	128,588,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	459,158,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	33,014,843.27
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	33,014,843.27
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	119,037,000.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	119,037,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	207,301.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	207,301.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	654,122,985.62	659,724,553.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	654,122,985.62	659,724,553.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	617,167,841.07	610,162,207.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	375,773,033.00	365,490,060.00
210101	Үндсэн цалин	375,773,033.00	270,103,341.00
210102	Нэмэгдэл	-	71,452,655.00
210104	Урамшуулал	-	23,934,064.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,082,169.75	48,143,338.75
210201	Тэтгэврийн даатгал	32,298,928.75	33,664,198.91
210202	Тэтгэмжийн даатгал	3,746,008.00	3,619,659.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,996,806.00	2,895,967.99
210204	Ажилгүйдлийн даатгал	730,948.00	723,891.97
210205	Эрүүл мэндийн даатгал	7,309,479.00	7,239,619.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,905,908.00	128,287,181.79
210301	Гэрэл, цахилгаан	4,273,908.00	5,334,681.79
210302	Түлш, халаалт	113,000,000.00	122,952,500.00
210303	Цэвэр, бохир ус	632,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	12,054,629.00	7,311,930.00
210401	Бичиг хэрэг	2,207,235.00	1,828,760.00
210402	Тээвэр, шатахуун	5,493,900.00	3,391,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	572,535.00	666,800.00

Ургамл сумын ЕБС-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	50,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,680,959.00	1,375,020.00
2105	Нормативт зардал	22,676,167.00	20,465,344.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,055,823.00	733,000.00
210502	Хоол, хүнс	21,620,344.00	19,732,344.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	740,800.00	1,863,900.00
210604	Урсгал засвар	740,800.00	1,863,900.00
2107	Томилолт, зочны зардал	968,000.00	930,000.00
210702	Дотоод албан томилолт	968,000.00	930,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	565,762.00	800,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	415,762.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	800,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,401,372.32	36,870,452.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,044,170.00	2,586,887.27
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,357,202.32	34,283,565.68
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,955,144.55	49,562,345.65
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	36,247,843.55	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	36,247,843.55	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	707,301.00	44,504,796.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	207,301.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	11,429,740.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	32,575,056.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	73,568.21
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	73,568.21
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	4,983,981.44
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,983,981.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(29,651,990.62)	(38,962,809.87)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(29,651,990.62)	(38,962,809.87)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	436,727,137.20	330,889,341.12	(241,224,742.43)	526,391,735.89
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	436,727,137.20	330,889,341.12	(241,224,742.43)	526,391,735.89
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(20,693,060.13)	(20,693,060.13)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх	436,727,137.20	330,889,341.12	(261,917,802.56)	505,698,675.76
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	436,727,137.20	330,889,341.12	(261,917,802.56)	505,698,675.76
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,746,811.68)	(1,746,811.68)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	436,727,137.20	330,889,341.12	(263,664,614.24)	503,951,864.08
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(32,269,337.87)	(32,269,337.87)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх	436,727,137.20	330,889,341.12	(295,933,952.11)	471,682,526.21

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	613,514,001.00	621,810,243.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,585,600.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	1,585,600.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,585,600.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,585,600.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	611,928,401.00	621,810,243.27
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	492,684,100.00	587,746,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	492,684,100.00	128,588,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	459,158,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	34,063,343.27
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	34,063,343.27
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	119,037,000.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	119,037,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	207,301.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	207,301.00	-
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	572,598,257.05	620,845,243.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	572,598,257.05	620,845,243.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	565,329,156.05	571,282,897.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	375,497,882.10	365,490,060.00
210101	Үндсэн цалин	272,659,368.50	259,770,133.45
210102	Нэмэгдэл	82,045,311.60	82,457,574.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	20,793,202.00	23,262,352.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,309,418.95	48,143,338.56
210201	Тэтгэврийн даатгал	37,810,073.15	33,557,838.56
210202	Тэтгэмжийн даатгал	2,344,694.90	3,646,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,930,008.54	2,917,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	474,921.36	729,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,749,721.00	7,292,700.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		

Ургамл сумын ЕБС-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,105,908.00	126,650,931.79
210301	Гэрэл, цахилгаан	4,273,908.00	5,334,681.79
210302	Түлш, халаалт	112,200,000.00	121,316,250.00
210303	Цэвэр, бохир ус	632,000.00	-
210304	Байрны түрээс		
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	9,146,535.00	7,283,067.27
210401	Бичиг хэрэг	1,446,800.00	895,597.27
210402	Тээвэр, шатахуун	5,493,900.00	3,391,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	572,535.00	808,600.00
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	50,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,533,300.00	2,137,520.00
2105	Нормативт зардал	11,100,480.00	17,352,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,145,230.00	1,000,000.00
210502	Хоол, хүнс	9,270,250.00	15,666,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	685,000.00	685,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,863,900.00
210604	Урсгал засвар	-	1,863,900.00
2107	Томилолт, зочны зардал	968,000.00	930,000.00
210702	Дотоод албан томилолт	968,000.00	930,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	565,762.00	800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	415,762.00	800,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,635,170.00	2,769,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,635,170.00	2,769,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,269,101.00	49,562,345.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,269,101.00	44,504,796.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	207,301.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,561,800.00	11,429,740.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	32,575,056.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	73,568.21
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	73,568.21
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	4,983,981.44
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,983,981.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	40,915,743.95	965,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,317,900.00	965,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,317,900.00	965,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,317,900.00	965,000.00

223001	Бусад хөрөнгө	1,650,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,667,900.00	965,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(6,317,900.00)</u>	<u>(965,000.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>-</u>	<u>-</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	34,597,843.95	-

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	589995600.00	582689350.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	589995600.00	582689350.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	576280600.00	570759610.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	365059100.00	365490060.00
210101	Үндсэн цалин	249177600.00	259770133.45
210102	Нэмэгдэл	94810000.00	82457574.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	21071500.00	23262352.55
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49282900.00	48143338.56
210201	Тэтгэврийн даатгал	34680600.00	33557838.56
210202	Тэтгэмжийн даатгал	3650600.00	3646400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2920500.00	2917100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	730100.00	729300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7301100.00	7292700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	128924500.00	126650931.79
210301	Гэрэл, цахилгаан	5331200.00	5334681.79
210302	Түлш, халаалт	123420000.00	121316250.00
210303	Цэвэр, бохир ус	173300.00	0.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	8512600.00	7109280.00
210401	Бичиг хэрэг	672200.00	805310.00
210402	Тээвэр, шатахуун	4655800.00	3391350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	808,600.00
210404	Ном, хэвлэл	1,008,200.00	965,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	50,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,376,400.00	1,089,020.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	18,476,800.00	17,352,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,000,000.00	1,000,000.00

210502	Хоол, хүнс	16,791,200.00	15,666,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	685,600.00	685,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,863,900.00	1,863,900.00
210604	Урсгал засвар	1,863,900.00	1,863,900.00
2107	Томилолт, зочны зардал	941,000.00	930,000.00
210702	Дотоод албан томилолт	941,000.00	930,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	800,000.00	800,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,419,800.00	2,419,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,419,800.00	2,419,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,715,000.00	11,929,740.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,715,000.00	11,929,740.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,215,000.00	11,429,740.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	589,946,900.00	587,673,331.79
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	589,946,900.00	587,673,331.79
131001	Улсын төсвөөс санхүүжих	130,788,400.00	128,514,831.79
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	459,158,500.00	459,158,500.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,063,343.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,063,343.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,488,287.27
2104	Хангамж, бараа материалын зардал	1,138,787.27
210401	Бичиг хэрэг	90,287.27
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,048,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	349,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	349,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,575,056.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,575,056.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	32,575,056.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	34,063,343.27
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,063,343.27
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	34,063,343.27

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ургамал сумын ЕБС-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Г.Заяа, ахлах аудитор Б.Дагвасүрэн нар гүйцэтгэж, хяналтыг газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хэрэгжүүлсэн.

Ургамал сумын ЕБС-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн ... дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ургамал сумын ЕБС нь 2021 онд сурлагын хоцрогдолгүй бүтээлчээр хамтран суралцаж, зөв төлөвшил эзэмшье зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ургамал сумын ЕБС-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 655.822,1 мянган төгрөгөөс 0,5 хувиар буюу 3.279,1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын (60-80 хувиар) буюу 1.967,4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1.748,2	1,4	-1.746,8
Бараа материал	49.039,6	51.725,1	2.685,5
Үндсэн хөрөнгө	495.960,0	462.641,5	-33.318,5
Нийт хөрөнгө	546.747,8	514.367,9	-32.379,9
Өр төлбөр	20.356,1	21.992,3	1.636,2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	526.391,7	492.375,6	-34.016,1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	546.747,8	514.367,9	-32.379,9

Авлага дансны үлдэгдэл 1.746,8 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагаас авах авлага барагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2.685,5 мянган төгрөгөөр хандиваар ирсан бараа материал болон, худалдан авалт хийсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 33.318,5 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалтай холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1.636,2 мянган төгрөгөөр өссөн нь халаалт ханган нийлүүлэгч аж ахуйн нэгжид төсөвт зардал хүрээгүйн улмаас дутуу төлөт хийн өглөг үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 34.016,1 мянган төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 589.995,6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 589.995,6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 128.588,4 мянган төгрөгийг, улсын төсвөөс 459.158,5 мянган төгрөгийн, нийт 587.746,9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 582.689,4 мянган төгрөгийг зарцуулж 5.57,5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд, улсын төсвөөс 34.063,3 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг орлогыг бүрдүүлэн, 34.063,3 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Нягтлан бодогч бүртгэлийг буруу бүртгэсэн, захирал нь өндөр насны тэтгэвэрт гарсан сургалтын менежерийг эгүүлэн ажилд нь томилохдоо цалингийн шатлал, бусад нэмэгдлийг буруу тооцоолон олгосон, урамшуулалт цалинг буруу тооцоолон өөртөө авсан зэрэг зөрчлүүд байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, хугацаа хоцроосон 3 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нягтлан бодогч нь бүртгэлээ сайжруулж, удирдлагын зүгээс санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 57.870,8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 43.602,0 мянган төгрөгийн алдааг залруулж, 11.429,7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгч, 2.838,5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоолоо.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн байдлын тайланд 3.698,7 мянган төгрөгийн, мөнгөн гүйлгээний тайланд 783,0 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтйн тайланд 34.063,3 мянган төгрөгийн, төсвийн гүйцэтгэлийн тайланд 5.057,5 мянган төгрөгийн залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Захирлын ажлыг сумын Засаг дарга 77 хувиар дүгнэж үр дүнгийн урамшууллыг 30 хувиар бодож цалин дээрээ тооцон авсан, өндөр насны тэтгэвэрт гарсан сургалтын менежерийг эгүүлэн ажилд нь томилохдоо цалинг өмнө нь ажиллаж байсан шатлалаар цалинжуулж, дагах бусад нэмэгдлүүдийг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" 41 дүгээр зүйлийн 41.2.2."батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах".

Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.1-д" Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно гэж заасныг зөрчсөн байна.

4.3 Албан шаардлага хүргүүлээгүй

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

- ✓ *Үдийн хоолны зардлыг бараа материалын тайлангаар дамжууллалгүй шууд зардалд бичсэн;*

1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ *Нягтлан бодох бүртгэлийг зөв бүртгэж, үдийн цайны зардлыг бараа материалын тайлангаар дамжуулан бүртгэж байх;*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.	Ургамал сумын ЕБС	8	57.8	6	43.6	1	2.8			1	11,4